



**НИЙГМИЙН
ДААТГАЛ**

**ЭДИЙН ЗАСГИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫГ
ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ
ТАЙЛАНГ ӨГӨХ,
БҮРТГҮҮЛЭХ
ЗААВАРЧИЛГАА**

“Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль”-ийн дагуу санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлан, барааны мэдүүлэг, эд хөрөнгийн бүртгэлийг ил тодоор шинэчлэн бүртгүүлж, тайлагнах талаарх зөвлөгөө мэдээллийг доорх хаяг, утсанд хандаж аваарай.

iltod.mta.mn

ТАТВАРЫН АСУУДЛААР-1800-1288 /3, 4/

www.mta.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН АСУУДЛААР-1800-1289;

www.ndaatgal.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН АСУУДЛААР-7000-1890, 1800-1890;

www.burtgel.gov.mn

ГААЛИЙН АСУУДЛААР-1800-1281;

www.customs.gov.mn

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР-51-263069, 51-264966

www.iltod.e-balance.mof.gov.mn



ХЭН?

- Хувь хүн
- Хуулийн этгээд

ЮУГ?

2015.04.01-ийг хүртэл хугацаанд нийгмийн даатгалд тайлагнаагүй нуусан, бууруулж тайлагнасан, НДШ-ээ төлөөгүй, дугуу төлсөн бол

ХЭЗЭЭ, ХААНА?

2015.12.31-ийг дуустал харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад

ХЭРХЭН?

Сайн дурын үндсэн дээр үнэн зөвөөр шинээр бүртгүүлэн тайлагнасан, нөхөн мэдүүлсэн, шимтгэл төлсөн тохиолдолд

**Алданги,
торгуулиас
нэг удаа
чолоолно.**

iltod.mta.mn

ХЭН?

Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр заасан:

- Хуулийн этгээд
- Иргэн (Иргэнтэй хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан цалин, хөлс олгосон)

ЮУГ?

Дараах үйлдлийг ил болгон мэдээлэх боломжтой. Үүнд:

- 2015.03.31-нийг дуустал хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаагүй цалин, хөлсөө шинээр болон шинэчлэн тайлагнаж нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөх орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан бол олгосон цалин, хөлсийг үнэн зөвөөр тайлагнаж, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх;
- Ажил олгогч нь тооцооны алдаа гаргаснаас урьд тайлагнасан даатгуулагчийн төрөл (код)-ийг буруу оруулсныг залруулан тайлагнах;

ХААНА?

Зөрчлийг харьяалах аймаг (Дүүрэг)-ийн Нийгмийн даатгалын хэлтэст тайлагнана.

ХЭРХЭН?

а. Ажил олгогч шинээр бүртгүүлэх бол:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ.
2. Татварын тайлангаа цахимаар өгч, баталгаажуулан, хэвлэж ирнэ.
3. Ажилтнуудад цалин олгосон баримт, ажилд авсан, чөлөөлсөн тушаалыг авч ирнэ.
4. (НД-7), (НД-8) тайланг цахимаар шивэхгүйгээр зөвхөн цаасаар гаргаж НДХ-т биеэр авч ирнэ.

5. Тайланг нийгмийн даатгалын ажилтан тулган шалгаж, шимтгэлийн дүнг тооцоолж гаргана.
6. Энэ хуулийн дагуу тайлагнасан шимтгэлийг бүрэн төлснөөр (НД-7), (НД-8)тайлан баталгаажна.
7. Тайланг баталгаажсаны дараа нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажуулна.

б. Бүртгэлтэй ажил олгогч тайланг шинээр болон шинэчлэн гаргах бол:

1. Татварын тайлангаа цахимаар өгч, баталгаажуулан, хэвлэж ирнэ.
2. Ажилтнуудад цалин олгосон баримт, ажилд авсан, чөлөөлсөн тушаал, нийгмийн даатгалын дэвтрийг тус тус авч ирнэ.
3. (НД-7), (НД-8) тайланг цахимаар шивэхгүйгээр зөвхөн цаасаар гаргаж НДХ-т биеэр авч ирнэ.
- Урьд тайлагнасан цалинг өөрчлөн тайлагнах бол бол "ЭЗИТБДТХ-ийн дагуу даатгуулагчийн цалинг өөрчлөн мэдүүлэх тайлан"-гийн маягтаар тайлан хийж ирнэ.
- Урьд тайлагнасан даатгуулагчийн төрлийг өөрчлөх бол "ЭЗИТБДТХ-ийн дагуу даатгуулагчийн төрөл өөрчлөн мэдүүлэх тайлан"-гийн маягтаар тайлан хийж ирнэ.
4. Тайланг нийгмийн даатгалын ажилтан тулган шалгаж, шимтгэлийн дүнг тооцоолж гаргана.
5. Энэ хуулийн дагуу тайлагнасан шимтгэлийг бүрэн төлснөөр (НД-7), (НД-8)тайлан баталгаажна.
6. Тайланг баталгаажсаны дараа нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажуулна.

ХЭЗЭЭ?

Бүртгүүлэх, тайлагнах, шимтгэл төлөх хугацаа: 2015 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуустал.